

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2020 оны 05. дугаар сарын 29.-ны өдрийн
Аялтуулт тушаалын 1 дүгээр хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН
ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ,
МЭРГЭШҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ,
ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот

2020 он

I. ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
НДЕГ	Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ХТНХНСТ	Хүнс тэжээл, Нийгмийн Халамжийн Нэмэлт Санхүүжилт Төсөл
МХНМХ	Монголын Хүний Нөөцийн Менежментийн Холбоо
ННДГ	Нийслэлийн нийгмийн даатгалын газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
БТГ	Бодлого төлөвлөлтийн газар
НХБХ	Нийгмийн хамгааллын бодлогын хэлтэс
СОНХАГ	Сургалт, олон нийт, хамтын ажиллагааны газар
НБ	Нийлүүлэх бүтээгдэхүүн
НД	Нийгмийн даатгал
ТЗ	Төрийн захиргаа
ТҮ	Төрийн үйлчилгээ
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл

АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ iv

ЗУРГИЙН ЖАГСААЛТ iv

НЭГ. УДИРТГАЛ

➤ Нийгмийн даатгалын тогтолцооны үүсэл, хөгжил 1

➤ Нийгмийн даатгалын өнөөгийн байдал 5

1.1. Нийгмийн даатгалын салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал 11

1.2. Салбарын хүний нөөцийн орчны шинжилгээ 6

1.3. Салбарын хүний нөөцийн талаарх бусад судалгаа, шинжилгээ 19

✓ Эрхэмлэх үнэ цэнийн дүн шинжилгээ 19

✓ Одоогийн сургалт хөгжлийн үйл ажиллагааны шинжилгээ 190

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, МЭРГЭШҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ БА ЗОРИЛТУУД

2.1. Алсын хараа буюу хэтийн зорилго 300

2.2. Эрхэм зорилго 300

2.3. Баримтлах зарчим 300

2.4. Хүний нөөцийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги 311

2.5. Стратегийн үр дүн 43

2.6. Стратегийг хэрэгжүүлэх схем, үйл ажиллагааны төлөвлөгөө 43

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ 45

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогч, даатгуулагчдын тоо
- Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн орлого, эх үүсвэрийн төрлөөр
- Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн зарлага, сангийн төрлөөр
- Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага
- Хүснэгт 5. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хувиар
- Хүснэгт 6. Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага
- Хүснэгт 7. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан
- Хүснэгт 8. Ажилгүйдлийн даатгалын сан
- Хүснэгт 9. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, дундаж тэтгэвэр
- Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо
- Хүснэгт 11. Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн 2019 оны батлагдсан орон тоо ба одоо ажиллаж байгаа ажилтны тоо
- Хүснэгт 12. Монгол Улсын 2018 оны хүн амын тоо ба Нийгмийн даатгалын ажилтны тоо
- Хүснэгт 13. НДБ-ын хүний нөөцийн дотоод орчны үнэлгээ
- Хүснэгт 14. НДБ-ын хүний нөөцийн гадаад орчны үнэлгээ
- Хүснэгт 15. Эрхэмлэх үнэ цэнийн үнэлгээ
- Хүснэгт 16. Процессийн зураглалын тайлбар
- Хүснэгт 17. Хүний нөөцийг хөгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт, бууралт
- Зураг 2. НД-ын байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтэц
- Зураг 3. НДЕГ-ын зохион байгуулалтын бүтэц
- Зураг 4. НД-ын ажилтнуудын нас, хүйсийн харьцаа
- Зураг 5. Сургалт зохион байгуулах процессийн зураглал
- Зураг 6. НД-ын ажилтнуудын сургалтын хэрэгцээ
- Зураг 7. НД-ын байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтэц /Сургалтын төвтэй/

НЭГ.УДИРТГАЛ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Монгол оронд нийгмийн даатгалын тогтолцооны үндэс суурь нь нийгмийн хамгаалал, нийгмийн хангамж гэсэн утга агуулгын хүрээнд анх хэрэглэгдэж, хөгжиж ирсэн байна.

Их Монгол Улс байгуулагдсан үеэс өнчин ядуусыг тэтгэх ажил төрийн бодлогоор зохицуулагдаж байсныг Монголын нууц товчоонд тэмдэглэсэн байдаг. Монголын үе үеийн хаадын бодлогод өнчин ядуусаас албан татвар авахгүй байхаас гадна тусlamж үзүүлэх сан бий болгох, ахмад настанд ногдох тэтгэмжийн хэмжээг насны ялгавартайгаар тус бүрчлэн нарийвчлан олгох зэрэг нийгмийн хангамжийн асуудлууд тусгагдаар ирсэн байна. 1206 онд Их хуралдайгаар баталсан Их засаг хуулинд “өтгөсийг хүндэлж, ядуусыг тэтгэх хэрэгтэй” гэж заасан байсан нь нийгмийн хангамжийн асуудал хуулийн зохицуулалттай байсны нотолгоо юм.

Ардын хувьсгалын он жилүүдэд биеийн хүчнийг үнэлэх, цалин хөлс олгох, өвдөх осолдоход тусlamж үзүүлэх, өндөр наслах, хөдөлмөрийн чадваргүй болох зэрэгт тэтгэвэр, тэтгэмж олгох зэрэг хүн амын нийгмийн хангамжийн асуудлыг хөгжүүлэх үндсэн төрлүүдийг тодорхойлж эхэлсэн ба 1925 оны Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн 25 дугаар тогтоолоор “Аливаа хүчин үнэлэгчдийн тухай” дүрмийг баталсан нь хөдөлмөрийн харилцаанаас гадна тэтгэмж олгох асуудлыг эрхзүйн баримтаар баталгаажуулсан явдал байв. Үүний дараа буюу 1940 оны Үндсэн хуульд “иргэд өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдахад материалын хангамж эдлэх үндсэн эрх”-ийг тунхагласан нь нийгмийн хангамжийн тогтолцоог бүрдүүлэхэд гол суурь нөхцөл болсон гэж үздэг.

Манай улсын нийгмийн даатгалын байгууллагын анхны бүтэц нь 1942 онд Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын дэргэд “Нийгмийн аюулаас хамгаалах хэлтэс” нэртэй байгуулагдсан алба юм. 1943 онд “Нийгмийг аюулаас хамгаалах тухай дүрэм”-ийг 12 бүлэг, 104 зүйлтэйгээр шинэчлэн баталж, уг дүрэмд эмнэлгийн тусlamж үнэгүй үзүүлэх, ажиллах хүчээ түр алдахад тэтгэмж олгох, нялх хүүхдийг хөхүүлэх, нас барагсдыг оршуулахад нэмэлт тэтгэмж олгох, эрхтэн дутуу бологсод тэтгэвэр олгох, нас хөгширсөн бол тэтгэвэр олгох, ажиллаж байсан гэрийн эзэн нас барсан бол гэр бүлд нь тусlamж олгох тухай асуудлыг тус тус нарийвчлан заажээ.

Монгол улсын тэтгэврийн хуулийг 1958 онд батлан мөрдүүлснээр иргэдийн тэтгэвэр авах эрх нь хуулиар баталгаажиж түүнд зарцуулах хөрөнгийг улсын төсөв, нийгмийн даатгалын хөрөнгөнөөс гаргахаар заасан байна.

Одоогийн тэтгэврийн даатгалын үндэс суурь болох тэтгэврийн хангамж нь 1970 он хүртэл Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад харьяалагдан нийгмийн даатгалын шимтгэлийн орлогоос тэтгэврийн хөрөнгийг санхүүжүүлж байсныг

1970 онд өөрчилж төрийн захиргааны байгууллагад төвлөрүүлж хөрөнгийн эх үүсвэрийг нь улсын төсвөөс гаргаж Сангийн яаманд эрхлүүлэх болсноор “Тэтгэвэр” төрийн нуруун дээр бүрэн шилжсэн байна. Харин ҮЭ-ийн байгууллага ажилтнуудаас нийгмийн даатгалын шимтгэл хураах ажлыг эрхлэн түүнээс хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний ба амаржсаны, оршуулгын тэтгэмж олгож, улсын амралт, рашаан сувиллын зардлыг бүхэлд нь санхүүжүүлж байжээ. Мөн хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн тэтгэврийн хангамжийг нэгдлүүд өөрсдөө хариуцаж байсныг 1980 оноос улсын системд хамруулсан нь тэтгэвэр авагчдын тоо, зардал өсөхөд нөлөөлсөн байна.

Тэтгэврийн харилцааг зохицуулж байсан нэг хууль 40 гаруй эрхийн актыг нэгтгэн 1990 онд улсын тэтгэврийн хуулийг батлан мөрдүүлсэн нь иргэдийн тэтгэврийн хангамжийн баталгааг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн боловч хөнгөлөлттэй журмаар эрт тэтгэвэрт гарагчдын тоо хэт нэмэгдэж, хамрах хүрээ нь өргөжиж, улсын төсвөөс дангаараа тэтгэврийн хөрөнгийн ачааллыг даах боломжгүйд хүргэсэн байна. Энэ нь тэтгэвэр тэтгэмжийг эрх зүйн хувьд хуульчлан тогтоох, иргэдэд олгож үйлчлэх талаар тус улсад сүүлийн 40 гаруй жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зөрөг сөрөг үр дагавар агуулж байсан хэдий ч нийгмийн даатгалын тогтолцоог үүсгэн хөгжүүлэх үндэс суурь нь болжээ.

Тэтгэврийн шинэ хуулийн үндсэн дээр нийгмийн хамгааллын тогтолцоо нь 1960 оноос 1990 он хүртэл нийгмийн хангамж, нийгмийн даатгал гэсэн 2 дэд бүтэцтэйгээр хөгжиж иржээ. 1990 онд Засгийн газраас нийгмийн хамгааллын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээ авч Хөдөлмөрийн яаманд Улсын нийгмийн хангамжийн газрыг байгуулж нийгмийн даатгал, нийгмийн хангамжийн нэгдсэн бодлого боловсруулах, даатгалын хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих, иргэдэд бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмж олгох, асрамж, халамжийн үйлчилгээг хариуцах асуудал хамаарах болсон байна.

1990 оны тэтгэврийн хуулиар анх “Тэтгэврийн сан”-г бий болгож уг сангийн эх үүсвэр нь аж ахуй нэгж байгууллага, хувийн үйлдвэрийн эзэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, төсвийн хөрөнгөнөөс бүрэлдэнэ” гэж зохицуулсан нь хөрөнгийн эх үүсвэрийн хувьд ажил олгогч, төрийн гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгчээ.

1992 оноос өмч хувьчлалын үр дагавраар аж ахуй нэгж байгууллагын задрал явагдсан, хувийн хэвшлүүд бүрэлдэж эхэлсэн, ажилгүйдэл нэмэгдэж, үйлдвэрлэл үйлчилгээ уналтанд орсноор төсвийн орлого эрс буурсан, зөвхөн улс хариуцан иргэдийн нийгмийн баталгааг хангадаг тогтолцоо өөрчлөгдсөн зэргээс шалтгаалан “Тэтгэврийн сан”-гийн хуучин бүтэц, нийгэм хангамжийн бодлого, үйл ажиллагааг үндсээр нь өөрчлөх, ялангуяа нийгмийн хамгааллынхаа төлөө иргэн хүний өөрийнх нь хувь нэмэр, үүрэг хариуцлагыг ухамсарлуулсан даатгалын шинэ тогтолцоонд шилжих зайлшгүй шаардлага болсон.

Нийгмийн хангамжийн бүхий л арга хэмжээ Тэтгэврийн сангаар дамжин санхүүжигдэж ялангуяа тэтгэвэр, тэтгэмжийн хөрөнгийн 70 гаруй хувь нь улсын төсвөөс 30 хүрэхгүй хувь нь нийгмийн даатгалын шимтгэлээс бүрэлдэж улсын төсвийн нийт зарлагын 20 гаруй хувийг нийгэм хангамжийн арга хэмжээнд зориулан зарцуулж байлаа. Энэхүү байдал нь ялангуяа тэтгэврийн тогтолцоо, хөрөнгийн эх үүсвэрийг зах зээлийн нөхцөлд нийцүүлэн зайлшгүй өөрчлөх бодит нөхцөл бүрэлдснийг харуулж байлаа.

Нөгөө талаар тэтгэвэрт гарагчдын тоо зөвхөн 1991 онд 94 мянган хүнээр нэмэгдэж, тэдгээрийн жил бүрийн өсөлт, тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээ нь улсын эдийн засгийн боломжоос давж, Монголын 2 хүн дутмын нэг нь ямар нэгэн тэтгэвэр, тэтгэмж авч байсан үе бөгөөд улсаар тэжээлгэх сэтгэлгээ давамгайлсан нөхцөл байдлыг нийгмийн даатгалын шинэ тогтолцоогоор халах чухал цаг үе боломж бүрэлдэн тогтох байлаа.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Нийгэм хангамжийн олон улсын холбоо, зарим орны мэргэжилтний туслалцаатайгаар зах зээлийн нөхцөл дэх нийгмийн хангамж, даатгалын тогтолцооны олон улсын хандлага, даатгал хөгжсөн орнуудын нийтлэг жишгээс монголд ямар хувилбар нь ашигтай болохыг судалж тогтоох ажлыг 1992, 1993 онд эрчимтэй зохион байгуулсан.

Нийгмийн хамгааллын салбар нь нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу хөгжлийн олон бодит хүчин зүйл болох эдийн засаг, улс төр, соёл, хүн ам зүйн нөлөөлөл дор хөгжиж байна. Нийгмийн хамгааллын тогтолцоог зах зээлийн харилцаа, дэлхийн жишигт нийцүүлэн шинэчлэх асуудал 1993 оноос эхэлж Улсын Их Хурлаас 1993 онд Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль, 1994 онд Нийгмийн даатгалын багц хуулиуд, 1999 онд Монгол Улсын төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар 2021 он хүртэл баримтлах үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдийг баталсан байна.

Эрхзүйн шинэчлэлээр бүрэлдэн бий болсон шинэ тогтолцооны хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлага зохион байгуулалтын бүтцэд Нийгмийн даатгал, Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн халамжийн хэрэгжүүлэгч агентлагууд бие даасан байгууллагын бүтэцтэйгээр бий болж, үйл ажиллагаа явуулах болжээ.

Нийгмийн даатгалын одоогийн зарчмыг сонгоходоо дараах гол үндэслэл, хандлагад тулгуурласан гэж үздэг. Үүнд:

1. Монгол оронд бүрэлдэн тогтсон нийгэм хангамжийн систем, түүнээс зах зээлийн орнуудад хэрэглэгдэж байгаа зарим хэм хэмжээ, арга зүйг боловсронгуй болгож уламжлалт чанарыг хадгалах,
2. Иргэдийн нийгмийн хамгаалалтай холбоотой тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг даатгалын харилцаанд нийцүүлэн өөрчлөх,
3. Иргэдийг өөрсдийнхөө нийгмийн баталгааны төлөө хариуцлага хүлээдэг болгож шимтгэл төлүүлэх шинэ харилцааг бий болгох,

4. Зах зээлийн орнуудад одоо байгаа дагнасан хувийн болон сайн дурын даатгалын зарим сөрөг үр дагавар агуулсан буюу шинэчлэн өөрчлөх шаардлагатай болсон хуучин тогтолцооны хэлбэрүүдээс татгалзаж, эв санааны нэгдлийн буюу үе үеийн хооронд нийгмийн баталгаагаа даатгалын төлбөр, тэтгэвэр тэтгэмжийн харилцаагаар нөхөн хангадаг зарчмыг илүү ирээдүйтэй гэж үзсэн.

5. Олон улсын хөдөлмөрийн байгуулага, Нийгэм хангамжийн олон улсын холбоонд нэгдсэн орнуудад 2030 он ба түүнээс цааш баримталж байгаа хэтийн хандлагыг харгалзсан байна.

Монгол Улсын нийгмийн даатгалын тогтолцоо нь дараах хууль эрхзүйн хүрээнд холбогдох бусад хууль тогтоомжууттай уялдан ажиллаж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тухай хууль - нийгмийн даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоож, нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх, сан бурдүүлэх, зарцуулах харилцаанд оролцогч талуудын эрхзүйн үндсийг тогтоож өгсөн.

2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль - нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоох, олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

3. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль - нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж, мэргэжлийн сургалтад хамруулах харилцааг зохицуулна.

4. Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль - нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох, төлбөр өгөхөд холбогдсон харилцааг зохицуулна.

5. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль - тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данстай холбогдсон харилцааг зохицуулна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол Улс зах зээлийн баримжаатай нийгэм, эдийн засгийн харилцаанд шилжсэнээр 1994 онд Нийгмийн даатгалын багц хуулийг баталсан ба 2015 онд Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ыг шинэчлэн баталж ажил олгогч болон даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогоор тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгодог тогтолцоог нэвтрүүлж эхэлснээс хойш 25 жилийн хугацаа өнгөрч байна.

Монгол улсын Нийгмийн даатгалын алба нь түүхэн хөгжлийн 80 шахам жилийг туулж, иргэд, даатгуулагч, ажил олгогч нарт нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэж ирсэн байгууллага юм.

Нийгмийн даатгалын байгууллага нь Нийгмийн даатгалын тухай багц хуулиудыг хэрэгжүүлэх, сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хуульд заасан хугацаанд тогтоон олгох, нийгмийн даатгалын үйлчилгээнд дэвшилтэт хэлбэр нэвтрүүлэх, тооцоолол судалгаа хийх, орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэй.

Нийгмийн даатгалын харилцаанд голлох байр суурийг ажил олгогч, даатгуулагч эзлэх бөгөөд тэдний хамрагдалт ба төлсөн шимтгэлийн хэмжээг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогч, даатгуулагчдын тоо

(хүний тоогоор)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Ажил олгогч	39496	41648	43122	43850	45892
Албан журмын даатгуулагч	832892	799798	799558	836487	807400
Сайн дурын даатгуулагч	185668	189238	228480	199143	237700

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn вэб сайт

Нийгмийн даатгалд 2014 онд 39.5 мянган, 2015 онд 41.6 мянган, 2016 онд 43.1 мянган, 2017 онд 43.6 мянган, 2018 онд 45.8 мянган аж ахуйн нэгж байгууллага; 2014 онд 832.9 мянган, 2015 онд 799.8 мянган, 2016 онд 799.6 мянган, 2017 онд 836.5 мянган, 2018 онд 807.4 мянган албан журмын даатгуулагч, 2014 онд 185.7 мянган, 2015 онд 189.2 мянган, 2016 онд 228.5 мянган, 2017 онд 199.1 мянган, 2018 онд 237.7 мянган сайн дурын даатгуулагч хамрагдсан байна.

**Хүснэгт 2. Нийгмийн даатгалын сангийн орлого,
эх үүсвэрийн төрлөөр**


(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Ажил олгогчийн төлсөн шимтгэл	587.6	607.0	660.6	753.2	790.1
Даатгуулагчийн төлсөн шимтгэл	491.0	504.4	577.5	679.1	613.7
Улсын төсвөөс олгосон хөрөнгө	253.3	292.6	494.9	570.2	609.8
Бусад орлого	39.3	61.8	42.3	65.8	76.4

Эх сурвалж: *Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn* вэб сайт

Нийгмийн даатгалын сангийн орлогын статистик мэдээллийг авч үзвэл 2018 оны эцсийн байдлаар ажил олгогчийн төлсөн шимтгэлээс 790.1 тэрбум төгрөг, даатгуулагчийн төлсөн шимтгэлээс 613.7 тэрбум төгрөг, улсын төсвөөс 609.8 тэрбум төгрөг бусад үйл ажиллагаанаас 76.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

Зураг 1. Нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт, бууралт



Эх сурвалж: *Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл*

**Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн зарлага, сангийн төрлөөр
(тэрбум төгрөг)**

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Тэтгэврийн даатгалын сан	984.6	1,171.8	1,303.9	1,415.8	1,619.3
Тэтгэмжийн даатгалын сан	78.4	87.0	92.3	100.0	113.8
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан	29.5	30.1	29.4	29.4	29.9
Ажилгүйдлийн даатгалын сан	17.8	22.4	31.6	34.6	34.4
Үйл ажиллагааны зардал	19.6	19.6	19.6	21.2	18.8

Эх сурвалж: *Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn вэб сайт*

**Хүснэгт 4. Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага
(тэрбум төгрөг)**

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
ОРЛОГО					
Шимтгэлийн орлого	688.7	714.1	765.2	877.1	1,133.7
Улсын төсвөөс олгосон хөрөнгө	253.3	292.6	494.9	570.2	479.9
Бусад орлого	16.4	29.7	2.6	3.2	5.7
ЗАРЛАГА					
Өндөр насны тэтгэвэр	724.8	867.8	973.7	1,065.6	1,222.5
Тахир дутуугийн тэтгэвэр	129.7	158.3	174.8	185.1	208.2
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	49.9	54.5	57.5	58.8	64.2
Цэргийн тэтгэвэр	80.3	91.2	97.8	106.4	122.9

Эх сурвалж: *Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn вэб сайт*

Хүснэгт 5. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хувиар

Шимтгэл төлөгч	Шимтгэлийн хэмжээ өөрчлөлт орсон хугацаа				
	1995 – 2007 он	2008 – 2017 он	2018 он	2019 он	2020 он
Ажил олгогч	13.5	7.0	8.0	8.5	9.5
Даатгуулагч	5.0	7.0	8.0	8.5	9.5
Нийт	19.0	14.0	16.0	17.0	19.0

Эх сурвалж: *Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл*

Хүснэгт 6. Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага
(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
ОРЛОГО					
Шимтгэлийн орлого	77.4	82.5	86.4	112.0	127.3
Бусад орлого	1.0	1.8	0.4	0.7	1.3
ЗАРЛАГА					
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	12.1	12.4	12.8	16.1	17.9
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	58.3	66.5	68.4	70.6	79.9
Оршуулгын тэтгэмж	8.1	8.2	11.1	13.3	14.1

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn вэб сайт

Хүснэгт 7. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
ОРЛОГО					
Шимтгэлийн орлого	77.4	82.5	86.4	112.0	127.3
Бусад орлого	1.0	1.8	0.4	0.7	1.3
ЗАРЛАГА					
Тахир дутуугийн тэтгэвэр	24.88	24.75	24.10	23.69	23.92
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	2.36	2.41	2.53	2.48	2.61
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж	0.42	0.56	0.58	0.60	0.72
Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр	0.04	0.03	0.03	0.02	0.02
ҮОМШӨ-ний улмаас тахир дутуу болсон даатгуулагчин шимтгэл	0.89	0.85	0.60	0.85	0.87
Сувиллын зардал	0.79	1.14	1.06	0.97	0.95
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	0.16	0.38	0.38	0.71	0.80
Бусад	-	-	0.11	0.07	0.05

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn вэб сайт

Хүснэгт 8. Ажилгүйдлийн даатгалын сан

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
ОРЛОГО					
Шимтгэлийн орлого	18.0	19.1	21.0	23.5	26.0
Бусад орлого	8.3	11.4	11.5	15.5	15.1
ЗАРЛАГА					
Ажилгүйдлийн тэтгэмж	17.8	22.4	31.6	34.6	34.3

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn вэб сайт

Хүснэгт 9. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, дундаж тэтгэвэр

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Дундаж тэтгэвэр (мян. төг)	226.0	254.1	283.0	314.0	345.5
Тэтгэвэр авагчдын тоо (мян. хүн)	344.8	362.2	376.8	393.5	406.8

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn вэб сайт

Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо

(тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
Тэтгэвэр авагчдын тоо	322,755	340,504	354,932	371,207	
Үүнээс	Өндөр насны	241,914	255,634	268,873	282,598
	Тахир дутуугийн	59,190	63,568	65,092	67,848
	Тэжээгчээ алдсаны	21,651	21,302	20,967	20,761
	Цэргийн	16,088	16,175	16,708	17,355

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл, www.1212.mn вэб сайт

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө нь даатгуулагч, ажил олгогч, төрийн оролцоотой холимог өмч учраас нийгмийн даатгалын байгууллагын удирдах дээд байгууллага нь уг харилцаанд оролцогч гурван талын төлөөлөл

бүхий Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл. Уг зөвлөлийн бүрэлдэхүүнд Засгийн газрын төлөөлөл, ажил олгогчийн төлөөлөл, даатгуулагчийн төлөөлөл тус тус багтдаг.

1.1. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Нийгмийн даатгалын үйл ажиллагааг гол эрхлэх байгууллага нь Нийгмийн даатгалын төв, орон нутгийн албад ба Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харъяа, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Тус байгууллага нь 2018 оны байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, 334 суманд 365 сумын нийгмийн даатгалын байцаач, ажилтантай буюу байгууллагын хэмжээнд нийтдээ 1421 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 11. Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн 2019 оны батлагдсан орон тоо ба одоо ажиллаж байгаа ажилтны тоо

(хүний тоогоор)

№	Ерөнхий ангилал	Батлагдсан орон тоо	Одоо ажиллаж байгаа
1	Нийгмийн даатгалын ерөнхий газар	82	80
2	Нийслэлийн нийгмийн даатгалын газар	25	25
3	Дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүд	408	432
4	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсүүд	901	884
	Бүгд	1416	1421

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газрын хүний нөөцийн судалгаа – 2019 он

Хүснэгт 12. Монгол Улсын 2018 оны хүн амын тоо ба Нийгмийн даатгалын ажилтны тоо

(хүний тоо, харьцуулсан хувиар)


Аймаг, хот	Хүн амын тоо	НД-ын ажилтны тоо, одоо ажиллаж байгаа	НД-ын ажилтны хүн амд эзлэх хувь	1 ажилтанд оногдох хүн амын тоо, дунджаар
Улсын дүн	3,238,479	1421	0.04%	2,279
Улаанбаатар	1,444,669	537	0.03%	2690
НДЕГ		80		
ННДГ		25		
Багануур	29,512	23	0.08%	1,283
Багахангай	4,399	6	0.14%	733

Баянгол	226,869	65	0.03%	3,490
Баянзүрх	343,619	69	0.02%	4,980
Налайх	37,608	20	0.05%	1,880
Сонгинохайрхан	321,150	66	0.02%	4,866
Сүхбаатар	145,335	63	0.04%	2,307
Хан-Уул	178,919	57	0.03%	3,139
Чингэлтэй	157,258	63	0.04%	2,496
Баруун бүс	408,979	213	0.05%	1,920
Баян-Өлгий	105,090	35	0.03%	3,003
Говь-Алтай	58,471	40	0.07%	1,462
Завхан	72,779	50	0.07%	1,456
Увс	84,309	42	0.05%	2,007
Ховд	88,330	46	0.05%	1,920
Хангайн бүс	604,353	269	0.04%	2,247
Архангай	96,720	44	0.05%	2,198
Баянхонгор	88,356	44	0.05%	2,008
Булган	62,214	39	0.06%	1,595
Орхон	105,987	38	0.04%	2,789
Өвөрхангай	117,112	52	0.05%	2,252
Хөвсгөл	133,964	52	0.04%	2,576
Төвийн бүс	513,438	284	0.06%	1,808
Говьсүмбэр	17,796	17	0.10%	1,047
Дархан-Уул	105,923	42	0.04%	2,522
Дорнговь	69,304	42	0.06%	1,650
Дундговь	46,628	38	0.08%	1,227
Өмнөговь	66,722	39	0.06%	1,711
Сэлэнгэ	111,403	54	0.05%	2,063
Төв	95,662	52	0.06%	1,840
Зүүн бүс	220,334	118	0.06%	1,867
Дорнод	80,984	38	0.05%	2,131
Сүхбаатар	62,322	34	0.06%	1,833
Хэнтий	77,028	46	0.06%	1,675


Эх сурвалж: Нийгмийн даатгалын өрөнхий газрын хүний нөөцийн судалгаа – 2019 он.

www.1212.mn

Зураг 2. НД-ын байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтэц




Зураг 3. НДЕГ-ын зохион байгуулалтын бүтэц



Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан чиг үүргийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газар хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг газраас өгсөн тайлан мэдээгээр 2019 оны 1-р улирлын байдлаар нийгмийн даатгалын байгууллагын батлагдсан орон тоо 1416, одоо ажиллаж байгаа 1421 ажилтантай.

Ажилтан, албан хаагчдын хүйсийн харьцааг авч үзвэл эрэгтэй ажилтан 32 хувь, эмэгтэй ажилтан 68 хувь байна.

Зураг 4. НД-ын ажилтнуудын нас, хүйсийн харьцаа



Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын ажилтнууд нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 6.1.2. төрийн захиргааны алба, 6.1.4. төрийн үйлчилгээний алба ангилалд тус тус хамаардаг бөгөөд нийт байгууллагын хэмжээнд Төрийн захиргаа (Т3)-ны 1110 ажилтан, Төрийн үйлчилгээ (ТҮ)-ний 302 ажилтан, гэрээт 9 ажилтан тус тус ажиллаж байна. Төв, орон нутгийн нийгмийн даатгалын ажилтнуудыг байршилаар нь авч үзвэл аймгийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд нийт ажилтны 62.2 хувь, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд 37.8 хувь нь ажиллаж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын ажлын байрны тогтвортой суурьшлыг улсад ажилласан жил, төрийн албанад ажилласан жил, тухайн байгууллагад ажилласан жил, тухайн албан тушаалд ажилласан жил гэсэн үзүүлэлтээр тус бүр тодорхойлж шинжилгээ хийж үзэхэд нийт байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа ажилтнуудын 41.3 хувь нь 5 хүртэл жил, 23 хувь нь 5-10 хүртэл жил, 26.3 хувь нь 10-20 хүртэл жил, 8.3 хувь нь 30-аас дээш жил тухайн байгууллагад ажиллаж байна. Харин одоо эрхэлж байгаа албан тушаал дээр ажилласан хугацааг нь авч үзэхэд 72.2 хувь нь 5 хүртэл жил, үүнээс 27.7 хувь нь 1 хүртэл жил ажиллаж байна.

Нийгмийн даатгалын үйл ажиллагааг Улаанбаатар хотын 9 дүүрэгт эрхлэн явуулж буй хэлтсүүдээс хамгийн өндөр ачаалалтай Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол, Хан-Уул дүүргүүд байна. Эдгээр дүүргүүдийн нийгмийн даатгалын 1 ажилтанд 3 мянгаас дээш хүн ам оногдож байна. Аймгийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс Баян-Өлгий, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул аймгуудын нийгмийн даатгалын хэлтэс хамгийн өндөр ачаалалтай буюу 1 ажилтанд 2.5 мянгаас дээш хүн ам оногдож байна.

Нийгмийн даатгалын ажилтнууд нь Төрийн албаны тухай хуулийн дагуу Төрийн захиргааны болон Төрийн үйлчилгээний ангилал зэрэглэлд хамаарч тухай ажлын байранд тавигддаг болзол шалгуурыг хангаж Төрийн албаны сонгон шалгаруулалтаар тэнцэж, томилогддог. Энэ нь тухайн ажлын байрны мэргэжлийн суурь ур чадварын бэлтгэл бүрэн хангагддаг гэж үзэх нөхцөл болно. Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ур чадварыг Нийгмийн даатгалын тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм”-ийн 1.4 дэх хэсэг, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын Сайдын 2018 оны A/25 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрхийг нь сэргээх, баталгаажуулах шалгалтын журам”-ын хүрээнд улсын хэмжээнд нэгдсэн байдлаар шалгалт зохион байгуулж, баталгаажуулдаг байна. Уг шалгалтыг зохион байгуулсан мэдээллээр шалгалт авах, бэлтгэх, тестийн нэгдсэн санд 1295 асуулт хариулт бүхий тест, 461 бодлого байдаг байна. 2018 онд уг шалгалтад 591 байцаагч оролцсоноос, 549 байцаагч шалгалтын босго онооноос өндөр оноо авч тэнцсэн бөгөөд 42 албан хаагч хангалтгүй оноо авсан байна. Нийт шалгалтад орсон байцаагч ажилтнуудаас 90.2 хувь нь амжилттай дүн авч тэнцжээ.

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг улсын байцаагчид шалгалтад бэлтгэх, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сорих, туршлага солилцох, шинэ санаа санаачилгыг дэмжих зорилгоор “Нийгмийн даатгал-миний мэргэжил” сэдэвт ажил мэргэжлийн уралдааныг энэ байгууллагын ажилтнуудын дунд тогтмол зохион байгуулдаг уламжлалтай. Энэ тэмцээн нь ажилтнуудын хөгжил, байгууллагын соёлыг илэрхийлсэн томоохон арга хэмжээний нэг бөгөөд жил бүр сонирхолтой хөтөлбөр, арга хэмжээнүүдээр баяжуулж, тэмцээнийг зохион байгуулсаар ирсэн байна.

1.2 САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

НДЕГ, ННДГ, аймаг дүүргийн НДХ-ийн 88 төлөөллийг оролцуулж НДБ-ын хүний нөөцийн гадаад, дотоод орчны шинжилгээг хийж давуу тал, сул тал, боломж, аюул эрсдэлийг тодорхойллоо.

Хүснэгт 13. НДБ-ын хүний нөөцийн дотоод орчны үнэлгээ

Байгууллагын соёл, үйлчилгээ	
Давуу тал / strength	Сул тал / weakness
<ul style="list-style-type: none"> • Байгууллагын соёл төлөвшсөн • Тогтсон стратегитай • ISO нэвтрүүлж эхэлсэн • Нэг цэгийн үйлчилгээ үзүүлдэг 	<ul style="list-style-type: none"> • Хүний нөөцийн бодлого алдагдсан • Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нөхцөлгүй • Урсгал шинэчлэл муу
Хүний нөөцийн бүрдүүлэлт	
Давуу тал / strength	Сул тал / weakness
<ul style="list-style-type: none"> • Мэргэшсэн хамт олон бүрдсэн • Хүний нөөцийн тогтвортой байдал • Багаар ажиллах чадвартай • Залуу ажилтан, албан хаагчидтай 	<ul style="list-style-type: none"> • Бүтэц, орон тоо оновчгүй • Улс төрийн нөлөөллөөр томилогддог • Зарим ажилтнууд мэргэжлийн бус • Жендерийн харьцаа алдагдсан
Сургалт хөгжил	
Давуу тал / strength	Сул тал / weakness
<ul style="list-style-type: none"> • Тогтмол сургалт зохион байгуулдаг • Сургалтанд хамрагдах идэвхий сайтай • Сургалт, сурталчилгаа сайн • Сургалтын хөтөлбөртэй • Ажлын байранд суралцдаг • НДХ-үүд хоорондоо туршлага солилцох боломжтой 	<ul style="list-style-type: none"> • Сургалтын төсөв, санхүү хүрэлцээгүй • Гадаад арга хэмжээнд орон нутаг, дүүргийн анхан шатны байцаагчийн хамралт бага • Шинэ ажилтныг сургах хөтөлбөр байхгүй • НД багц хуулиас бусад хуулийн мэдлэг бага
Ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаа	
Давуу тал / strength	Сул тал / weakness
<ul style="list-style-type: none"> • Ажлын байр, ажиллах орчин сайн • Цалин хөлс тогтмол • Материаллаг бааз, орчин сайтай 	<ul style="list-style-type: none"> • Нийгмийн баталгаа сул • Бусад салбартай харьцуулахад цалин хөлс бага • Урамшуулал байхгүй • Дотоод орчин, тохижилт муу

<ul style="list-style-type: none"> Хамт олны уур амьсгал сайн Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулдаг 	/зарим нэгж/
Тогтворт суурьшил	
Давуу тал / strength	Сул тал / weakness
<ul style="list-style-type: none"> НДБ-д ажилладагаараа бахархдаг Тогтвортой ажиллах хүсэл эрмэлзэлтэй 	<ul style="list-style-type: none"> Сайн ажилтан тогтдоггүй Ажилтанг орон нутагт тогтворт сууршилтай ажиллуулах хөтөлбөр байхгүй
Мэдээллийн технологи ашиглалт	
Давуу тал / strength	Сул тал / weakness
<ul style="list-style-type: none"> Үйлчилгээ цахимжсан Тоног төхөөрөмжөөр хангагдсан Цахим сургалт хийх боломжтой 	<ul style="list-style-type: none"> Техник, шинэ программ хангамжийн уялдаа холбоо сул Тайлан мэдээ нэг дороос гардаггүй Мэдээлэл, технологийн шинэчлэл Сумын байцаагч интернетэд холбогдох нь хязгаарлагдмал
Гүйцэтгэл	
Давуу тал / strength	Сул тал / weakness
<ul style="list-style-type: none"> Цаг ашиглалт сайн Урьдчилан судалгаа гаргах боломжтой Идэвхи оролцоотой Санаачлага сайтай 	<ul style="list-style-type: none"> Ажлын ачаалал их Хүлээх үүрэг хариуцлага их Албан хэрэг хөтлөх болон компьютер, программ эзэмшлийн чадвар сул Хөрвөх чадвар бага Өөрчлөлтийг хүлээн авах чадвар сул

Хүснэгт 14. НДБ-ын хүний нөөцийн гадаад орчны үнэлгээ

Хүний нөөцийн гадаад орчны үнэлгээ	
Боломж / Opportunity	Аюул / Threat

- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> • Өрсөлдөгчгүй монополь • Цахим орчны шилжилт • Гадаад орны туршлага нэвтрүүлэх боломжтой • ОУ-ын байгууллагын төсөл хөтөлбөрөөр байгууллагаа чадавхжуулах, үйл ажиллагаагаа сайжруулах боломжтой • ТББ-аар зарим үйлчилгээг хийлгэх боломжтой • Эрх зүйн орчинг сайжруулах Санхүүжилт тогтвортой • Иргэдээс ирж буй санал гомдол дээр үндэслэн үйлчилгээг илүү боловсронгуй болгох • Төр болон Хувиараа хөдөлмөр эрхлэгч зах зээл • Орон нутгийн бусад байгууллагатай хамтран ажиллах боломжтой. | <ul style="list-style-type: none"> • Улс төрийн шинжтэй нөлөөлөл их • Цахим хамгаалалт сул • Хуурамч бичиг баримт шалгах боломж бага • Хяналт шалгалт хариуцлага адил биш /дотоод, гадаад/ • Орон тооны цомхотгол, бүтцийн өөрчлөлт • Хууль бус томилгоо • Хүнд суртал • Нийгмийн хандлага, нэр хүнд муу • Төрийн байгууллагын уялдаа холбоо сул |
|---|---|

1.3 САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БУСАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

Эрхэмлэх үнэ цэнийн дүн шинжилгээ

Хүснэгт 15. Эрхэмлэх үнэ цэнийн үнэлгээ

ШҮХЭР	Үнэ цэнэ	Үнэлгээ
1. Бид үргэлжид мэргэшсэн, чадварлаг нэгдмэл баг байна.	1. Хөгжил дэвшилд хөтлөгч байна.	***
	2. Байнгын суралцагч байна.	*+***
	3. Хүсэл тэмүүлэлтэй, ажил мэргэжлээрээ хөрвөх чадвартай байх	*+**
	4. Мэдлэг, мэдээллээ түгээн, дэлгэрүүлэгч байх	**+***
	5. Эрсдэлийг урьдчилан тооцож байх	**
2. Бид хуулиа дээдлэн, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллана.	1. Өргөсөн тангарагтаа үнэнч байх	***
	2. Мэргэжлийн өндөр ёс зүйтэй байх	***
	3. Нээлттэй ил тод байх	***
	4. Үүрэг хариуцлагаа ухамсарлах	***
	5. Адил тэгш харилцааг эрхэмлэх	***
3. Бид оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, түншлэлийг хөгжүүлнэ.	1. Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх	***
	2. Багийн амжилтыг чин сэтгэлээсээ бүтээгч байх	***
	3. Ололт амжилттаа хуваалцаж, хамтран хөгжих	***
	4. Саад бэрхшээлийг хамтран даван туулах чадвартай байх	**+***
	5. Харилцан үр дүнтэй ажиллах	**
4. Бид найрсагаар хандаж, тусч сэтгэлээр үйлчилнэ.	1. Бусдад хүмүүнлэг, энэрэнгүй тусч сэтгэлээр хандах	***
	2. Хамт олон, харилцагч талуудын эерэг харилцааг хөгжүүлэх	***
	3. Байгууллагынхаа соёл уламжлалыг хүндэтгэн дээдлэх	***
	4. Бусдад итгэл найдвар төрүүлж, урам зориг өгөх	***
	5. Нөхцөл байдлыг бодитой үнэлэх чадвартай байх	**+***
5. Бид уламжлал, шинэчлэлийг бүтээлгээр хослуулан хөгжиж дэвшинэ.	1. Арвин мэдлэг, өөдрөг үзэл бодол, бүтээлч хандлагаараа үлгэрлэх	***
	2. Мэдлэгийг тасралтгүй бүтээгч, байгууллагаа хөгжүүлэгч байх	***
	3. Өөрчлөлт шинэчлэлд тууштай байж, эрсдэлийг даван туулагч байх	**+***
	4. Шинэлэг санал, санаачлагыг дэмжин хэрэгжүүлэгч байх	***
	5. Эрч хүч, хурдтай байх	***


Тайлбар: * - Мэдлэг ** - Ур чадвар *** - Хандлага

Нийгмийн даатгалын байгууллагад мөрдөгдөж байгаа эрхэмлэх үнэ цэнэд дүн шинжилгээ хийж, ажилтан албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хандлагын алинд нь чиглэсэн талаар үнэлгээ өгөхөд мэдлэгт 8%, ур чадварт 28%, хандлагад 88% чиглэсэн байна үр дүн гарлаа.

Одоогийн сургалт хөгжлийн үйл ажиллагааны шинжилгээ

НДЕГ 2015 онд олон улсын ISO9001:2008 стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн. Сургалт зохион байгуулах процесс нь 2015 оны 10 сарын 26-ны өдрийн НДЕГ-ын даргын А/118 тушаалаар батлагдсан НД-ын төв байгууллагын үйл явц(процесс)-ын зураглалын эмхтгэлд дараах байдлаар харуулжээ.

Зураг 5. Сургалт зохион байгуулах процесийн зураглал



2015 оны 10 сарын 26-ны өдрийн НДЕГ-ын даргын А/118 тушаалаар батлагдсан НД-ын төв байгууллагын үйл явц (процесс)-ын зураглалын эмхтгэлд харуулснаар сургалт зохион байгуулах процесийг дараах алхмуудаар тайлбарлан харуулсан байна.

Хүснэгт 16. Процессийн зураглалын тайлбар

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР				ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ ЯВЦ (ПРОЦЕСС)-ЫН ЗУРАГЛАЛ				Дугаар: ТГ-20-2015 Батлагдсан он: 2015.10.28 Хувилбар: 1 Шинэчлэгдсэн огноо: Хуудасны тоо: 88/124						
Процессын алхам бүрт тавигдах	Орц	Орцод хамаарах мэдээлэл болон тавигдах шаардлага			Үйл ажиллагааны дараалал	Алхамыг хэрэгжүүлэхэд хамаарах мэдээлэл			Гарц	Гарцад хамаарагдах мэдээлэл болон тавигдах шаардлага				
		Ямар шаардл агууд тавигдах вэ?	Хэрхэн цуглуулж, бүрдүүлэх вэ?	Хэрхэн нийлүүлэх вэ?		Алхамыг хэрэгжүүлэхдэд ямар ажлууд хийгдэх вэ?	Алхамын хэрэгжилтэнд хэн, хэн оролцох вэ?	Хэрхэн хэрэгжүүлэх вэ?		Ямар шаардла гүуд тавигдах вэ?	Гарцыг хэн хэрэглэх вэ	Хэмжүүрийн үзүүлэлт	Бүртгэл	
Энэ алхамын ажлыг хийх ийн тулдашиглах орцын нэр	Орц тус бүрт тавигдах шаардл агааг багтаасан дэлгэрэн нгүй мэдээлэл	Орц тус бүрт тавигдах шаардл агааг багтаасан дэлгэрэн нгүй мэдээлэл	Орцыг нийлүүлэх суваг, хэлбэр, хугацаа	Орцыг бүрдүүлэг ч алба, хэлтэс, нэгж	Тухайн алхамын үед хийгдэх ажлын нэр	Алхамын алхамын үед хийгдэх ажлууд	Алхамыг хэрэгжүүлэхэд мөрдөг дөх процес, баримт бичгүүд талууд	Хамтран ажиллагх бусад оролцогч талууд	Алхамыг хэрэгжүүлэхэд мөрдөг дөх процес, баримт бичгүүд	Тухайн алхамаас ямар бүтээгдэх эхүүн, үр дүн, баримт бичиг гарах гарцын нэр	Гарцад тавигдаж байгаа шаардла гүүг багтаасан дэлгэрэн гүй мэдээлэл	Гарцыг хүлээн авагч буюу хэрэглэгч	Гарц нь шаардлагад нийцэж байгаа эсэхийг хэмжих шалгур болон холбогдох үзүүлэлт	Тухайн алхамыг хэрэгжүүлсэн нотолгоо болох бүртгэлийн нэрс
